

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2024/07/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2024 он	Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: batstetsegs@audit.gov.mn Аудитор: Э.Одгэрэл Утас: 70378845 Цахим хаяг: odgerele@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бүрэлтэн гудамж-1, 14 дугаар баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45056,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим хуудан: darhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № 69

төрийн _____ -ийн № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол тус төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар орлогоороо зардлаа нөхөж чадаагүйгээс 38,526.7 мянган төгрөгийн өр үүссэн зөрчил нь бидний тогтоосон 4,910.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасантай тус тус нийцээгүй, Санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв нь өөрийн орлогоор санхүүждэг байгууллага юм. Тайлант онд сургалт зохион байгуулж 8,438.5 мянга, түрээсийн орлогоор 50,286.0 мянга, торгууль, бусад орлогоор 123.7 мянга, нийт 58,848.2 мянган төгрөгийн орлого олсон нь өнгөрсөн оноос 9,319.8 мянган төгрөгөөр буурсан байна.

009020110

хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг Аймгийн хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс 98.8 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red square official stamp of the State Audit Agency of Mongolia is centered. It contains the Mongolian text "МОНГОЛЫН АУДИТЫН АГЫ" (State Audit Agency of Mongolia) and "УЛСЫН АУДИТЫН АГ" (State Audit Agency). A large, stylized blue handwritten signature is written over the stamp.

Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,593,371.89</u>	<u>7,662,380.67</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,107,547.89	1,359,148.41
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	534,909.43	282,513.43
31110	Төгрөг	534,909.43	282,513.43
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,572,638.46	1,076,634.98
3121	Төгрөг	4,572,638.46	1,076,634.98
31213	Арилжааны банк дахь харилцах	4,572,638.46	1,076,634.98
33	АВЛАГА	2,008,076.00	2,337,047.00
335	Бусад авлага	2,008,076.00	2,337,047.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,008,076.00	2,337,047.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,477,748.00	3,966,185.26
354	Хангамжийн материал	4,477,748.00	3,966,185.26
35410	Бичиг хэргийн материал	245,460.00	239,315.26
35420	Аж ахуйн материал	4,232,288.00	3,726,870.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>513,116,202.41</u>	<u>483,376,233.85</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	513,116,202.41	483,376,233.85
391	Газар	47,150,000.00	47,150,000.00
392	Биет хөрөнгө	447,024,869.21	434,114,233.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	518,250,581.00	518,250,581.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(105,067,069.92)	(113,704,579.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	21,880,610.00	21,880,610.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,342,313.60)	(19,588,829.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,172,900.00	7,172,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,172,900.00)	(7,172,900.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,409,500.00	37,409,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,106,438.27)	(10,133,047.83)
393	Биет бус хөрөнгө	18,941,333.20	2,111,999.88
39301	Програм хангамж	50,840,000.00	50,840,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(31,898,666.80)	(48,728,000.12)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>524,709,574.30</u>	<u>491,038,614.52</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3,792,532.76</u>	<u>38,526,688.68</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,792,532.76	38,526,688.68
413	Өглөг	3,792,532.76	38,526,688.68
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,779,032.76	32,034,274.68
4136	Бусад өглөг	13,500.00	6,492,414.00
41361	Байгууллагад төлөх өглөг	13,500.00	6,492,414.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>520,917,041.54</u>	<u>452,511,925.84</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	520,917,041.54	452,511,925.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	446,650,000.00	446,650,000.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	446,650,000.00	446,650,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	(33,216,039.46)	(101,621,155.16)
51210	Өмнөх үеийн үр дүн	(33,216,039.46)	(33,216,039.46)
51220	Тайлант үеийн үр дүн		(68,405,115.70)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	107,483,081.00	107,483,081.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>524,709,574.30</u>	<u>491,038,614.52</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	68,167,958.00	58,848,183.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,167,958.00	58,848,183.00
120	Нийтлэг татварын бус орлого	68,167,958.00	58,848,183.00
120003	Торгуулийн орлого		116,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	67,842,650.00	58,724,553.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,349,000.00	8,438,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	53,493,650.00	50,286,053.00
120009	Бусад орлого	325,308.00	7,630.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	98,968,086.31	127,253,298.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	98,968,086.31	127,253,298.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	98,878,086.31	127,253,298.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,787,812.29	49,095,683.11
210101	Үндсэн цалин	36,615,103.45	44,862,948.41
210102	Нэмэгдэл	5,172,708.84	4,032,734.70
210105	Гэрээт ажлын хөлс		200,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,827,794.08	5,659,147.29
210201	Тэтгэврийн даатгал	4,827,794.08	5,659,147.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,698,236.00	18,902,900.00
210301	Гэрэл, цахилгаан	8,511,632.00	9,175,174.00
210302	Түлш, халаалт	4,884,728.00	7,427,726.00
210303	Цэвэр, бохир ус	2,301,876.00	2,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,109,691.38	8,316,468.74
210401	Бичиг хэрэг	374,810.00	775,718.42
210402	Тээвэр, шатахуун	487,479.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,206,865.38	1,951,971.00
210404	Ном, хэвлэл	34,000.00	407,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	660,000.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,346,537.00	5,181,779.32
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	12,620,000.00
210604	Урсгал засвар		12,620,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,037,738.00	1,462,275.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	965,430.00	1,039,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	28,600.00	176,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,708.00	
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/		246,075.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,416,814.56	31,196,824.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		711,606.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		745,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,416,814.56	29,739,968.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,000.00	-

2132	Бусад урсгал шилжүүлэг	90,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	90,000.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(30,800,128.31)</u>	<u>(68,405,115.70)</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(30,800,128.31)</u>	<u>(68,405,115.70)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	66,949,618.00	59,024,630.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,949,618.00	59,024,630.00
120	Нийтлэг татварын бус орлого	66,949,618.00	59,024,630.00
120002	Хүүгийн орлого		116,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	66,949,618.00	58,395,582.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,519,621.00	5,750,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,429,997.00	52,645,582.00
120009	Бусад орлого		513,048.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	77,773,957.35	62,773,029.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,773,957.35	62,773,029.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,723,957.35	62,773,029.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,787,812.29	26,499,588.48
210101	Үндсэн цалин	41,098,427.29	26,199,588.48
210105	Гэрээт ажлын хөлс	689,385.00	300,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,047,189.68	-
210201	Тэтгэврийн даатгал	9,047,189.68	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,698,236.00	17,121,914.00
210301	Гэрэл, цахилгаан	8,511,632.00	9,377,148.00
210302	Түлш, халаалт	4,884,728.00	5,444,766.00
210303	Цэвэр, бохир ус	2,301,876.00	2,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,492,981.38	7,818,396.00
210401	Бичиг хэрэг	415,900.00	210,500.00
210402	Тээвэр, шатахуун	487,479.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,206,865.38	4,232,957.00
210404	Ном, хэвлэл	34,000.00	407,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,348,737.00	2,967,939.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	660,000.00	7,820,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	660,000.00	-
210604	Урсгал засвар		7,820,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,037,738.00	2,056,275.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	965,430.00	1,039,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,000.00	594,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	28,600.00	176,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,708.00	-
210810	Хөтөлбөр арга хэмжээий зардал		246,075.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,456,856.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		711,606.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		745,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,050,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	90,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,960,000.00	-
213304	Хөрөнгийн	3,960,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(10,824,339.35)	(3,748,399.48)
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	=
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(10,824,339.35)	(3,748,399.48)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,606,579.24	5,107,547.89
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,107,547.89	1,359,148.41

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	446,650,000.00	107,483,081.00	(2,415,911.15)		551,717,169.85
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	446,650,000.00	107,483,081.00	(2,415,911.15)	-	551,717,169.85
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн			(30,800,128.31)		(30,800,128.31)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	446,650,000.00	107,483,081.00	(33,216,039.46)	-	520,917,041.54
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	446,650,000.00	107,483,081.00	(33,216,039.46)	-	520,917,041.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	446,650,000.00	107,483,081.00	(33,216,039.46)	-	520,917,041.54
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			(68,405,115.70)		(68,405,115.70)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	446,650,000.00	107,483,081.00	(101,621,155.16)	-	452,511,925.84

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Жижиг Дунд үйлдвэрийг дэмжих төв нь хууль зүйн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж болон гарааны бизнес эрхлэгчдийг тэдний бизнесийн үйл ажиллагаа үйлдвэрлэл арга зүйн дэмжлэг үзүүлэх замаар зах зээлд бие даан хөгжих чадвартай бизнес эрхлэгч болгон хөгжүүлэх төлөвшүүлэх зорилго дэвшүүлсэн.

Тус байгууллага 2023 онд жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид бизнесийн сургалт явуулах, зөвлөгөө өгөх, мэдээллийн нэг цэгийн үйлчилгээгээр үйлчлэх зэргээр төрийн байрыг үр ашигтай ашиглахаар ажиллаж байна.

4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2,319.0 мянган төгрөгийн хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 3 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байгаа тул Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж байх, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

5. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орлогоороо зардлаа бүрэн санхүүжүүлж чадахгүй байгаагаас тайлант албан хаагчдад өгөх цалингийн 14,772.3 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн 9,512.7 мянга, хувь хүний орлогын албан татварын 3,970.2 мянга, байгууллагад 6,478.9 мянга, нийт 34,734.2 мянган төгрөгөөр байгууллагын өр өссөн байна.

6. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 39,184.8 мянган төгрөгийн зөрчилд¹ 658.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах 38,526.7 мянган төгрөгийн зөвлөмж өглөө. Үүнд.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6.1 Төлбөрийн акт

Тайлант онд захирал, бичиг хэргийн ажилтны 658.1 мянган төгрөгийн гар утасны төлбөрийг байгууллагын зардлаас төлсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.1, “Үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад бусад гар утасны зардал”, гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

6.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

6.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөртэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт

Орлогоороо зардлаа нөхөж чадахгүйгээс тайлант онд 38,526.7 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна. Энэ нь Төсийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.8, “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж

Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, өр төлбөр үүсгэхгүй байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	/мянган төгрөгөөр/ Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны Тоо	Тоо	Дүн
Захирал, бичиг хэргийн ажилтны гар утасны төлбөрийг байгууллагын зардлаас төлсөн байна.	1	658.1	1	658.1	-	-	-	-	-	-	-	-
Орлогоороо зардлаа нөхөж чадаагүйгээс ер үүссэн байна.	1	38,526.7					1	38,526.7				
Дүн	2	39,184.8	1	658.1	-	-	1	38,526.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Хөрөнгө, мөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрийг мэдээлээгүй	3	2,319.0	-	-	-	-	3	2,319.0	
Дүн	3	2,319.0	-	-	-	-	3	2,319.0	

8. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
2	Төсөл, хөтөлбөр	-	-	-	-	-	-	-	-
3	ЗГТС	-	-	-	-	-	-	-	-
4	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-
5	ТЕЗ	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ	1	1	-	-	-	1	-	-